



I-VI/2021

Тархаасан: 2021 оны 7 дугаар сарын 19



Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2021 оны эхний хагас жилд 24.4 хувиар өслөө.

Улсын хэмжээнд бүх төрлийн тээврээр 2021 оны эхний хагас жилд 28.4 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 5.6 (24.4%) сая тонноор өссөн байна. Энэхүү өсөлтөд авто тээврээр тээсэн ачаа 4.0 (47.5%) сая тонноор өссөн нь голлон нөлөөлжээ.

Бүх төрлийн тээврээр 2021 оны эхний хагас жилд 27.0 сая хүн (давхардсан тоогоор) зорчсон нь өмнөх оны мөн үеэс 34.8 (56.3%) сая хүнээр буурсан байна. Зорчигчдын тоо буурахад авто тээврээр зорчигчид 33.7 (55.5%) сая хүнээр буурсан нь голлон нөлөөлжээ.

Хүснэгт 1. Бүх төрлийн тээврийн үндсэн үзүүлэлт, жил бүрийн эхний улиралд

Үзүүлэлт	2019	2020	2021*	Бүх төрлийн тээврээр тээсэн ачаа 2021 оны 2 дугаар улиралд, өмнөх улирлаас 7.3 (41.0%) сая тонн, зорчигчид 12.6 (63.7%) сая хүнээр тус тус буурсан байна.
	I-VI	I-VI	I-VI	
Тээсэн ачаа, сая тонн	32.1	22.8	28.4	
Зорчигчид, сая хүн	91.1	61.8	27.0	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	881.8	637.8	675.3	

Бүх төрлийн тээврийн орлого 2021 оны эхний хагас жилд 675.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 37.5 (5.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Авто тээврийн орлого 25.4 (13.8%) тэрбум төгрөг, төмөр замын тээврийн орлого 26.6 (7.3%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь бүх төрлийн тээврийн орлого өсөхөд нөлөөлсөн байна. Харин бүх төрлийн тээврийн орлого 2021 оны 2 дугаар улиралд 324.0 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 27.3 (7.8%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Авто замын тээвэр

Авто тээврээр 2021 оны эхний хагас жилд 12.4 сая тонн ачаа, давхардсан тоогоор 27.0 сая хүн тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс тээсэн ачаа 4.0 (47.5%) сая тонноор өсөж, зорчигчид 33.7 (55.5%) сая хүнээр буурсан байна.

Ачаа тээврийн өсөлтөд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлт 3.9 сая тонн буюу 54.1 хувиар өссөн нь нөлөөлжээ, харин зорчигч тээврийн хувьд нийслэлийн тээврээр зорчигчид (давхардсан тоо) 33.1 (59.9%) сая хүнээр буурсан нь нөлөөлсөн байна.

Харин 2021 оны 2 дугаар улиралд, авто замын тээврээр тээсэн ачаа өмнөх улирлаас 7.0 (72.3%) сая тонн, зорчигчид 12.6 (63.8%) сая хүнээр буурсан байна.

Хүснэгт 2. Авто тээврийн үндсэн үзүүлэлт


Үзүүлэлт	2019	2020	2021*	Авто тээврийн салбарын орлого 2021 оны эхний хагас жилд 210.2 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 25.4 (13.8%) тэрбум төгрөгөөр өссөн байна. Энд уул уурхайн бүтээгдэхүүний тээвэрлэлтийн орлого өссөн нь голлон нөлөөлсөн байна.
	I-VI	I-VI	I-VI	
Тээсэн ачаа, сая тонн	18.9	8.4	12.4	
Уул уурхайн бүтээгдэхүүн	16.1	7.1	11.0	
Зорчигчид, сая хүн	89.2	60.6	27.0	
Нийслэлийн нийтийн тээвэрээр зорчигчид	81.4	55.2	22.2	
Тээврийн орлого, тэрбум төгрөг	335.9	184.8	210.2	

Харин авто тээврийн орлого 2021 оны 2 дугаар улиралд 80.5 тэрбум төгрөг болж, өмнөх улирлаас 49.3 (38.0%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Төмөр замын тээвэр

Төмөр замын тээврээр 2021 оны эхний хагас жилд 15.9 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 1.6 (10.9%) сая тонноор өсжээ.

Зураг 1. Төмөр замын тээврээр тээсэн ачаа, мянган тонн, сараар



Төмөр замын тээврээр тээсэн ачааны өсөлтөд дотоодын ачаа 1.0 (20.3%) сая тонн, импортын ачаа 272.1 (19.4%) мянган тонн, дамжин өнгөрөх ачаа 243.3 (12.5%) мянган тонноор тус тус өссөн нь нөлөөлсөн байна.


Төмөр замын тээврээр тээсэн ачаа 2021 оны 6 дугаар сард 2.6 сая тонн болж, өмнөх сараас 22.1 (0.9%) мянган тонноор өссөн байна.

Хүснэгт 3. Төмөр замаар дотоод, гадаадад тээсэн ачаа, бүтээгдэхүүний бүлгээр, дүнд эзлэх хувиар, жил бүрийн эхний хагас жилийн байдлаар

Үзүүлэлт	2019 I-VI	2020 I-VI	2021*I-VI
Бүгд	100.0	100.0	100.0
Уул уурхайн бүтээгдэхүүн	84.5	85.5	82.2
Барилгын материал	8.4	7.8	12.2
Мод, модон материал	0.5	0.5	0.3
Хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн	1.0	0.9	1.1
ХАА-н гаралтай бүтээгдэхүүн	1.6	1.2	0.8
Хар төмөр (хаягдал, рельс г.м)	1.4	1.5	1.1
Бусад	2.6	2.6	2.3

Төмөр замын тээврээр 2021 оны эхний хагас жилд тээсэн нийт ачаанд түргэн муудах бүтээгдэхүүн 2.1 дахин, барилгын материал 70.3 хувь, үйлдвэрийн машин, тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл 47.7 хувь, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн 34.6 хувь, уул уурхайн бүлгийн бүтээгдэхүүн 5.2 хувиар голлон өссөн байна.

Зураг 2. Төмөр замын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Төмөр замын тээврээр 2021 оны эхний хагас жилд ковид-19 өвчнөөс үүдэн гамшгаас хамгаалах бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдон зорчигч тээвэрлээгүй байна.


Төмөр замын тээврийн орлого 2021 оны эхний хагас жилд 392.7 тэрбум төгрөг болсон нь өмнөх оны мөн үеэс 26.6 (7.3%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Энэ өсөлтөд барилгын материал, хүнсний өргөн хэрэглээний бүтээгдэхүүн болон түргэн муудах бүтээгдэхүүний тээвэрлэлт нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Төмөр замын тээврийн орлого 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 675.9 (1.0%) сая төгрөгөөр буурч, 67.1 тэрбум төгрөг болжээ.

Агаарын тээвэр

Агаарын тээврээр 2021 оны эхний хагас жилд 1.9 мянган тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үеэс 511.3 (35.8%) тонноор өссөн байна.


Зураг 3. Агаарын тээврээр тээсэн ачаа, тонн, сараар



Агаарын тээврээр 2021 оны эхний хагас жилд дотоодод 8.0 (0.4%) тонн ачаа тээсэн нь өмнөх оны мөн үеэс 33.2 (80.6%) тонноор буурсан байна. Харин олон улсад тээсэн ачаа 1.9 (99.6%) мянган тонн болсон нь өмнөх оны мөн үеэс 544.5 (39.2%) тонноор өссөн байна.

Агаарын тээврээр тээсэн ачаа 2021 оны 6 дугаар сард 352.1 тонн болж, өмнөх сараас 105.5 (23.0%) тонноор буурсан байна.

Зураг 4. Агаарын тээврээр зорчигчид, мянган хүн, сараар



Агаарын тээврээр 2021 оны эхний хагас жилд давхардсан тоогоор 58.1 мянган хүн зорчсон нь өмнөх оны мөн үеэс 238.9 (80.4%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын тээврээр 2021 оны 6 дугаар сард 15.8 мянган хүн зорчиж, өмнөх сараас зорчигчид 6.7 (73.0%) мянган хүнээр нэмэгдсэн байна.

Агаарын тээврээр орон нутагт зорчигчид 2021 оны эхний хагас жилд 36.4 (62.6%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 123.2 (77.2%) мянган хүнээр буурсан байна. Энэхүү бууралтад Оюутолгой-Даланзадгад чиглэлийн зорчигчид 85.2 хувь, Улаангом чиглэлийн зорчигчид 91.8 хувь, Улиастай чиглэлийн зорчигчид 89.8 хувиар тус тус буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Агаарын тээврээр олон улсад зорчигчид 2021 оны эхний хагас жилд 21.7 (37.4%) мянган хүн болж, өмнөх оны мөн үеэс 115.7 (84.2%) мянган хүнээр буурсан байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 оны эхний хагас жилд 72.3 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 14.5 (16.7%) тэрбум төгрөгөөр буурсан байна.

Агаарын үндэсний тээвэрлэгчдийн орлого 2021 оны 6 дугаар сард өмнөх сараас 5.3 (39.9%) тэрбум төгрөгөөр өсөж, 18.5 тэрбум төгрөг болсон байна.

Тооцох аргачлал:

- **Ачаа эргэлт.** Нэг тонн ачааг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Ачаа эргэлт болон тээвэрлэсэн ачааны хэмжээг тээврийн төрөл тус бүр дээр ачааны төрлөөр тооцно. Ачаа эргэлтийг тонн километрээр илэрхийлнэ.
- **Зорчигч эргэлт.** Нэг зорчигчийг нэг км-ээс дээш зайд тээвэрлэсэн тээврийг хэмждэг нэгж юм. Зорчигч эргэлтийг хүн.км-ээр илэрхийлнэ.
- **Шилжүүлсэн тонн километр.** Тээврээр гүйцэтгэсэн олон төрөл, хэлбэрийн ажил, үйлчилгээг тусгай коэффициентуудыг ашиглан нэг нэгжид буюу тонн километрт шилжүүлсэн үзүүлэлт юм. Энэ үзүүлэлт нь тээврийн төрөл тус бүрт харилцан адилгүй тооцогддог.
- **Тээврийн орлого.** Тээврийн үйлчилгээ үзүүлсний төлбөр болгож авч байгаа ертгийн нийлбэр юм. Өөрөөр хэлбэл тээврийн байгууллагуудын үйл ажиллагааны үр дүн буюу ачаа, зорчигч тээвэрлэлт түүнтэй холбогдсон үйл ажиллагаанаас орсон орлого юм.



Эх үүсвэр: ҮСХ, тээврийн үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжийн мэдээ

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 8 дугаар сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас: (976-51)-266414

Эдийн засгийн статистикийн газрын,
Статистикч О.Мандахзориг
Утас: (976-51)-261563

